

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар А/75

Өлгий

**Эрүүл мэндийн салбарын 2023-2026 оны
стратеги төлөвлөгөө
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 21 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/609 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн салбарын 2023-2026 оны стратеги төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2. Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны төлөвлөгөө, стратеги төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. “Эрүүл мэндийн салбарын 2023-2026 оны стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангахад мэргэжил, арга зүйгээр хангаж, жил бүр хяналт үнэлгээ хийж, үр дүнг тооцож ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга /Ш.Иманхан/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга /М.Рүстем/-д даалгасугай.

ДАРГА



Н.САКЕН

6ЮЕ0019

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 27 сарын 27 өдрийн 75 тоот
тушаалын нэгдүгээр хавсралт
Б.ОЕ.0019


**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2023-2026 он

**Эрүүл мэндийн салбарын 2023-2026 оны стратеги төлөвлөгөөний бүтэц,
агуулга**

Бүлэг 1. Нийтлэг үндэслэл	1
Бүлэг 2. Мандатын шинжилгээ	2
Бүлэг 3. Алсын хараа	5
Бүлэг 4. Эрхэм зорилго	5
Бүлэг 5. Орчны шинжилгээ	5
Бүлэг 6. Стратегийн зорилго	7
Бүлэг 7. Стратегийн зорилго ба салбар, нутаг дэвсгэрийн нэгж байгууллагын бүтцийн уялдаа зураглал	7
Бүлэг 8. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин	8
Бүлэг 9. Стратеги төлөвлөгөө 2023-2026	10

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ



1.1. Товч танилцуулга

Эрүүл мэндийн газар нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон нутгийн өөрөө удирдах байгууллага, аймгийн Засаг даргын шийдвэр, холбогдох бусад хууль тогтоомж, стандартыг харьяа эрүүл мэндийн байгууллагуудад хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, бодлого арга зүйгээр хангах, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийх, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах эрх, үүргийг гүйцэтгэх төрийн байгууллага юм. Мөн иргэдэд тэгш хүртээмжтэй, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх боломжоор хангах, байгууллагын үйл ажиллагаа нь иргэдэд нээлттэй, ил тод, иргэдийн оролцоог хангасан байх зарчмыг баримталдаг. Эрүүл мэндийн газрын харьяа аймгийн нэгдсэн эмнэлэг 1, өрхийн эрүүл мэндийн төв 4, сум, тогсоны эрүүл мэндийн төв 14, Зоонозын өвчин судлалын төв 1, хувийн хэвшлийн ортой эмнэлэг 5, клиник эмнэлэг 19, сувилал 2, халдваргүйтгэл, шавьж, мэрэгч устгалын байгууллага 5, эм хангамжийн байгууллага 6, эмийн сан 60 ажиллаж байна.

Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн сайдын 2020 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, бүтэц үйл ажиллагааны чиглэл”-ийн нэгдүгээр хавсралтаар 4 хэлтсийн бүтэцтэй ажиллаж байна. Үүнд:

1. Удирдлага төлөвлөлт, санхүү, мэдээллийн хэлтэс
2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтэс
3. Хяналт шалгалтын хэлтэс
4. Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс

Эрүүл мэндийн газар нь “Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг Баян-Өлгий аймагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр 2017-2021 он”-ыг боловсруулан батлуулж, хэрэгжүүлсэн ба Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/609 дүгээр тушаалаар “Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө батлах тухай” батлагдан гарсантай холбогдуулан Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах шаардлагатай болсон.

1.2. Үндэслэл

Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа 2050”, аймгийн Засаг даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөрийг тус тус үндэслэж боловсруулсан. Стратеги төлөвлөгөөг Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийн хангах журам болон төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу боловсруулсан.

1.3. Хууль тогтоомжийн орчин

- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Эрүүл ахуйн тухай хууль

- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Гамшгаас хамгаалах тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль




ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын дагуу салбарын чиг үүргийн мандатыг 2023 онд хийсэн.

Дүн шинжилгээ хийхдээ эрүүл мэндийн салбарын чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Эрүүл мэндийн статистик үзүүлэлтүүд

2.1 . Сүүлийн 5 жилийн хүн амын өсөлтийн үзүүлэлт



Аймгийн хүн амын тоо жилээс жилд нэмэгдэж байна. 2022 оны байдлаар хүн амын тоо 109899 байна.

2.2. Хүн амын тоо, насны бүтцээр

Насны бүлэг	2018	2019	2020	2021	2022
0-4	13744	14075	14367	14646	14635
5-9	11898	12175	12629	12944	13292
10-14	10240	10355	10629	11012	11244
15-19	10087	9800	9743	9677	9721
20-24	9556	8721	8670	8924	9029
25-29	9387	9181	9098	9093	8877
30-34	7857	7960	8219	8436	8549
35-39	6495	6641	6832	7030	7181
40-44	5960	5925	6041	6156	6231
45-49	5227	5306	5407	5529	5593

50-54	4210	4282	4411	4628	4803
55-59	3322	3532	3581	3764	3776
60-64	2273	2425	2636	2667	2884
65-69	1214	1385	1379	1649	1785
70-74	783	774	882	877	933
75-79	692	697	600	592	580
80-84	344	328	411	437	476
85-89	228	228	202	194	181
90-94	62	49	86	99	113
95-99	25	23	23	18	15
100+	4	8	7	4	1

2.3. Хүн амын тоо, хүйсийн бүтцээр

Хүйс	2018	2019	2020	2021	2022
Нийт дүн	103765	103908	105853	108376	109899
Эрэгтэй	51781	51855	52877	54186	54813
Эмэгтэй	51984	52053	52976	54190	55086

Эмэгтэй хүйсийн харьцаа бага зэрэг илүү байна.

2.4. Дундаж наслалт, хүйсээр

Он	Дундаж	Эрэгтэй	Эмэгтэй
2018	73.11	70.31	75.36
2019	73.32	70.36	75.74
2020	73.62	70.58	76.09
2021	74.8	71.09	76.52
2022	74.6	71.6	77.0

Хүн амын дундаж наслалт 2018 оноос 1.49-ээр нэмэгдэж, эрэгтэй, эмэгтэй дундаж наслалт аль аль нь нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2.5. Төрөлтийн тоо

Он	2018	2019	2020	2021	2022
Төрөлтийн тоо	2913	2971	2849	2923	2762

Тус аймгийн төрөлтийн тоо улс, аймгийн дунджаас өндөр байна.

2.6. Нас баралтын тоо

Хүйс	2018	2019	2020	2021	2022
Эрэгтэй	290	324	262	288	288
Эмэгтэй	212	234	205	213	213
Нийт	502	558	467	501	501

2.7. Эх, хүүхдийн эндэгдэл

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022
Эхийн эндэгдэл, 100000 амьд төрөлтөд	0	0	174.6	68.3	72.1
Нялхсын эндэгдэл, 1000 амьд төрөлтөд	17.8	20.7	16.4	16.4	14.4
Нярайн эндэгдэл, 1000 төрөлтөд	8.2	12.0	9.7	11.6	8.2
5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөд	25.0	25.1	19.9	18.4	20.9

Эх, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл улс, аймгийн дунджаас өндөр үзүүлэлттэй байна.

2.8. Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан, 10000 хүн амд

Д/д	Тэргүүлэх шалтгаан	2018	2019	2020	2021	2022
1	Амьсгалын тогтолцооны өвчлөл	1067.03	1162.14	802.72	615.32	1449.0
2	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	902.24	1932.14	2074.93	2266.27	2090.9
3	Шээс бэлгийн тогтолцооны өвчин	806.21	1153.95	1008.1	978.77	1096.9
4	Зүрх судасны тогтолцооны өвчин	883.34	1075.83	1108.31	973.35	1334.4
5	Мэдрлийн тогтолцооны өвчин	140.63	230.69	598.87	619.4	766.7

2.9. Хүн амын нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан 10000 хүн амд

Д/д	Тэргүүлэх шалтгаан	2018	2019	2020	2021	2022
1	Зүрх судасны тогтолцооны өвчин	20.74	22.44	19.07	20.82	21.7
2	Хавдар	9.35	12.71	8.39	8.40	8.25
3	Гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	4.97	4.14	4.39	4.95	3.94
4	Хоол боловсруулах тогтолцооны өвчин	2.82	2.79	1.91	2.52	3.48
5	Амьсгалын тогтолцооны өвчлөл	4.19	3.18	2.67	1.93	1.09

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ давамгайлсан эмнэлгийн байгууллагуудын хүчин чадлыг бэхжүүлэн, улсын стандартын түвшинд хүргэж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, тэгш байдал, чанар үр дүнг сайжруулан хүн амын өвчлөлийг бууруулж, дундаж наслалтыг уртасгахад оршино.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Үйлчлүүлэгчдийн эрхийг дээдэлсэн үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээг хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрхэмлэнэ.

Зорилтууд:

1. Хүн амын зан үйлийг өөрчлөх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх улмаар зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийг бууруулахад чиглэсэн Мэдээлэл Сургалт Сурталчилгааны үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах.
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эндэгдлийг бууруулах.
3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлж, сайжруулах.
4. Хүн амыг зайлшгүй шаардлагатай эм, биобэлдмэлээр жигд, хүртээмжтэй тасралтгүй хангах.
5. Үйлчлүүлэгчдэд ээлтэй, эрүүл мэндийг дэмжсэн тусламж, үйлчилгээ бий болгох.
6. Салбарын хэмжээнд мэдээллийн технологийн дэд бүтэц, харилцаа холбооны үйлчилгээг тогтмолжуулах.
7. Харьяа Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж, дэмжиж ажиллах.
8. Эрүүл мэндийн салбарт чиглэсэн санхүүгийн урсгалын тогтвортой байдлыг хангах.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Давуу тал	Сул тал
Аймгийн Засаг даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөрт эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх заалтууд тусгагдсан. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хууль батлагдсанаар эмнэлгийн засаглал зах зээлийн зарчмаар хөгжих боломж бүрдсэн. Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоо шинээр батлагдсан. Эрүүл мэндийн яам, орон нутгаас жил бүр хөрөнгө оруулалт хийдэг. Шилэн дансны хууль хэрэгжиж, төсөв санхүүгийн үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал сайжирсан. Эрүүл мэндийн байгууллагууд шаардлагатай нарийн мэргэжлийн эмчээр хангагдсан хувь өндөр. Эрүүл мэндийн ажиллагсадын цалин, төрөөс олгох тэтгэмжийн хэмжээ нэмэгдсэн. Олон улсын байгууллагуудын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалт хийгддэг. Тоног төхөөрөмжийн хангалт нэмэгдэж байна. Интернэт цахим сүлжээтэй, ихэнх үйл ажиллагаа цахимжсан.	Эрүүл мэндийн салбарын удирдах мэргэшсэн ажилтны нөөцийн хомсдол үүсэх эрсдэлтэй. Эрүүл мэндийн газрын удирдах ажилтны манлайлал харилцан адилгүй. Мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх тусгайлсан хөтөлбөргүй. Эмч мэргэжилтнүүдийн гадаад сургалт хангалтгүй. Эмч, ажиллагсдын ёс зүйн хандлагын төлөвшил жигд биш. Эмч, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд эрхзүйн орчин бүрдээгүй. Эмнэлгийн түргэн тусламж үзүүлэх түргэн тусламжийн тээврийн хэрэгсэл хангалтгүй. Эмзэг бүлэгт чиглэсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар хангалтгүй. Оношлогоо, эмчилгээний зарим тоног төхөөрөмж дутагдалтай. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хандлагын байдал үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжид нөлөөлдөг. Урьдчилан сэргийлэх үзлэгээр илэрсэн өвчлөлийн эрүүлжилт хангалтгүй.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ давамгайлсан эмнэлгийн байгууллагуудын хүчин чадлыг бэхжүүлэн, улсын стандартын түвшинд хүргэж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, тэгш байдал, чанар үр дүнг сайжруулан хүн амын өвчлөлийг бууруулж, дундаж наслалтыг уртасгахад оршино.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Үйлчлүүлэгчдийн эрхийг дээдэлсэн үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээг хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрхэмлэнэ.

Зорилтууд:

1. Хүн амын зан үйлийг өөрчлөх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх улмаар зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийг бууруулахад чиглэсэн Мэдээлэл Сургалт Сурталчилгааны үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах.
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эндэгдлийг бууруулах.
3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлж, сайжруулах.
4. Хүн амыг зайлшгүй шаардлагатай эм, биобэлдмэлээр жигд, хүртээмжтэй тасралтгүй хангах.
5. Үйлчлүүлэгчдэд ээлтэй, эрүүл мэндийг дэмжсэн тусламж, үйлчилгээ бий болгох.
6. Салбарын хэмжээнд мэдээллийн технологийн дэд бүтэц, харилцаа холбооны үйлчилгээг тогтмолжуулах.
7. Харьяа Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж, дэмжиж ажиллах.
8. Эрүүл мэндийн салбарт чиглэсэн санхүүгийн урсгалын тогтвортой байдлыг хангах.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Давуу тал	Сул тал
Аймгийн Засаг даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөрт эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх заалтууд тусгагдсан. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хууль батлагдсанаар эмнэлгийн засаглал зах зээлийн зарчмаар хөгжих боломж бүрдсэн. Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоо шинээр батлагдсан. Эрүүл мэндийн яам, орон нутгаас жил бүр хөрөнгө оруулалт хийдэг. Шилэн дансны хууль хэрэгжиж, төсөв санхүүгийн үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал сайжирсан. Эрүүл мэндийн байгууллагууд шаардлагатай нарийн мэргэжлийн эмчээр хангагдсан хувь өндөр. Эрүүл мэндийн ажиллагсадын цалин, төрөөс олгох тэтгэмжийн хэмжээ нэмэгдсэн. Олон улсын байгууллагуудын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалт хийгддэг. Тоног төхөөрөмжийн хангалт нэмэгдэж байна. Интернэт цахим сүлжээтэй, ихэнх үйл ажиллагаа цахимжсан.	Эрүүл мэндийн салбарын удирдах мэргэшсэн ажилтны нөөцийн хомсдол үүсэх эрсдэлтэй. Эрүүл мэндийн газрын удирдах ажилтны манлайлал харилцан адилгүй. Мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх тусгайлсан хөтөлбөргүй. Эмч мэргэжилтнүүдийн гадаад сургалт хангалтгүй. Эмч, ажиллагсдын ёс зүйн хандлагын төлөвшил жигд биш. Эмч, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд эрхзүйн орчин бүрдээгүй. Эмнэлгийн түргэн тусламж үзүүлэх түргэн тусламжийн тээврийн хэрэгсэл хангалтгүй. Эмзэг бүлэгт чиглэсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар хангалтгүй. Оношлогоо, эмчилгээний зарим тоног төхөөрөмж дутагдалтай. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хандлагын байдал үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжид нөлөөлдөг. Урьдчилан сэргийлэх үзлэгээр илэрсэн өвчлөлийн эрүүлжилт хангалтгүй.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ давамгайлсан эмнэлгийн байгууллагуудын хүчин чадлыг бэхжүүлэн, улсын стандартын түвшинд хүргэж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмж, тэгш байдал, чанар үр дүнг сайжруулан хүн амын өвчлөлийг бууруулж, дундаж наслалтыг уртасгахад оршино.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД


Үйлчлүүлэгчдийн эрхийг дээдэлсэн үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээг хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрхэмлэнэ.

Зорилтууд:

1. Хүн амын зан үйлийг өөрчлөх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх улмаар зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийг бууруулахад чиглэсэн Мэдээлэл Сургалт Сурталчилгааны үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах.
2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эндэгдлийг бууруулах.
3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцааны соёлыг дээшлүүлж, сайжруулах.
4. Хүн амыг зайлшгүй шаардлагатай эм, биобэлдмэлээр жигд, хүртээмжтэй тасралтгүй хангах.
5. Үйлчлүүлэгчдэд ээлтэй, эрүүл мэндийг дэмжсэн тусламж, үйлчилгээ бий болгох.
6. Салбарын хэмжээнд мэдээллийн технологийн дэд бүтэц, харилцаа холбооны үйлчилгээг тогтмолжуулах.
7. Харьяа Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангаж, дэмжиж ажиллах.
8. Эрүүл мэндийн салбарт чиглэсэн санхүүгийн урсгалын тогтвортой байдлыг хангах.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Давуу тал	Сул тал
Аймгийн Засаг даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөрт эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх заалтууд тусгагдсан. Эмнэлгийн тусламж үйлчилгээний хууль батлагдсанаар эмнэлгийн засаглал зах зээлийн зарчмаар хөгжих боломж бүрдсэн. Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоо шинээр батлагдсан. Эрүүл мэндийн яам, орон нутгаас жил бүр хөрөнгө оруулалт хийдэг. Шилэн дансны хууль хэрэгжиж, төсөв санхүүгийн үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал сайжирсан. Эрүүл мэндийн байгууллагууд шаардлагатай нарийн мэргэжлийн эмчээр хангагдсан хувь өндөр. Эрүүл мэндийн ажиллагсадын цалин, төрөөс олгох тэтгэмжийн хэмжээ нэмэгдсэн. Олон улсын байгууллагуудын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалт хийгддэг. Тоног төхөөрөмжийн хангалт нэмэгдэж байна. Интернэт цахим сүлжээтэй, ихэнх үйл ажиллагаа цахимжсан.	Эрүүл мэндийн салбарын удирдах мэргэшсэн ажилтны нөөцийн хомсдол үүсэх эрсдэлтэй. Эрүүл мэндийн газрын удирдах ажилтны манлайлал харилцан адилгүй. Мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх тусгайлсан хөтөлбөргүй. Эмч мэргэжилтнүүдийн гадаад сургалт хангалтгүй. Эмч, ажиллагсдын ёс зүйн хандлагын төлөвшил жигд биш. Эмч, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд эрхзүйн орчин бүрдээгүй. Эмнэлгийн түргэн тусламж үзүүлэх түргэн тусламжийн тээврийн хэрэгсэл хангалтгүй. Эмзэг бүлэгт чиглэсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар хангалтгүй. Оношлогоо, эмчилгээний зарим тоног төхөөрөмж дутагдалтай. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хандлагын байдал үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжид нөлөөлдөг. Урьдчилан сэргийлэх үзлэгээр илэрсэн өвчлөлийн эрүүлжилт хангалтгүй.



Компьютерүүд вирусын программаар бүрэн хангагдсан. Хөдөлмөр хамгаалал, нормын хувцасаар тогтмол хангадаг. Ажил байдлын тодорхойлолтыг батлуулсан ба гүйцэтгэлийн гэрээ байгуулан хэрэгжилтийг ханган ажилладаг. Эмч, ажилчдын ажлын гүйцэтгэлийг тогтмол үнэлэн улирлаар урамшуулал олгодог. Эмч ажиллагсадад хоолны мөнгө тогтмол олгодог. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, хуулийн ажилтантай. Эрүүл мэндийн газрын дэргэд ёс зүйн салбар зөвлөл ажилладаг. Хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр мэргэжлийн нийгэмлэгүүдтэй хамтарч ажилладаг. Эмийн тендер, бусад худалдан авалтыг өөрсдөө зохион байгуулах боломжтой. Эрүүл мэндийн газар нь зориулалтын байртай, өрөө тасалгаа хүрэлцээтэй, тав тухтай. Эрүүл мэндийн газар цахим хуудасаар дамжуулан үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажилладаг. Харьяалах эрүүл мэндийн байгууллагуудад тогтмол хяналт үнэлгээ зохион байгуулж, зөвлөмж арга зүйгээр ханган ажиллаж байна. Төрийн байгууллагын ABLE програм ашигладаг. Шуурхай удирдлагын нэгж, мэдээллийн төвтэй. НЭМТ-ийн тогтвортой бүтэцтэй. Сувилагчийн нөөц хангалттай.	Эмнэл зүйн лабораторигүй тул нотолгоонд суурилсан тусламж үзүүлэхэд бэрхшээлтэй. Хүн амын эрүүл мэндийн боловсрол эрүүл зөв зан үйлийн төлөвшил хангалтгүй. Эмийн агуулах байхгүй тул эмийн нөөц бүрдүүлэх боломжгүй тул зарим эм тасардаг байдал түгээмэл. Орон нутгийн удирдлага, хамтын ажиллагаа хангалтгүй.
Боломж	Аюул
Эрүүл мэндийн газрын удирдах ажилтнууд, мэргэжилтнүүдийг гадаад, дотоодын сургалтанд хамруулж, чадавхжуулах, Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг санхүүжүүлэх асуудлыг болон хээгжүүлэх шаардлатай дэд хөтөлбөрүүдийг аймгийн Иргэдийн төлөлөгчдийн хуралд тавьж шийдвэрлүүлэх, Төсвийн удирдлага, хуул эрхзүйн чиглэлээр бүх шатны менежерүүдийг сургаж, чадавхжуулах, Хүний нөөцийн ажлын гүйцэтгэл, үр дүн хариуцлагад суурилсан урамшуулал олгох, Эмч, ажиллагсадын ёс зүйн хандлагыг сайжруулах хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх	Төсөв санхүүгийн хомсдол байгууллагын хөгжилд сөргөөр нөлөөлөх, Чадварлаг хүний нөөцийн хомсдолд орох, Ёс зүйн хандлага нь үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг бууруулах, Хүний нөөцийн тогтвор суурьшил хангалтгүй байх, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нөөцийн бүрдүүлэлт, Эмнэлгийн барилга байгууламжийн эрсдлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн болон нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүн амыг эрүүлжүүлэхэд оршино.



ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА САЛБАР, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА ЗУРАГЛАЛ

2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд нэгдсэн эмнэлэг 1, өрхийн эрүүл мэндийн төв 4, сум, тогсоны эрүүл мэндийн төв 14, Зоонозын өвчин судлалын төв 1, хувийн хэвшлийн ортой эмнэлэг 5, клиник эмнэлэг 19, сувилал 2, халдваргүйтгэл, шавьж, мэрэгч устгал 5, эм хангамжийн байгууллага 6, эмийн сан 60 ажиллаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байна.

Эрүүл мэндийн байгууллагын зураглал

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Удирдлага
төлөвлөлт,
санхүүгийн
хэлтэс

Эмнэлгийн
тусламж,
үйлчилгээний
хэлтэс

Хяналт-
шинжилгээ,
үнэлгээ,
мэдээллийн

Нийгмийн
эрүүл мэндийн
төв

Нэгдсэн
эмнэлэг


ЗӨСТ

Өрхийн ЭМТ

Сум, тогсоны
ЭМТ

Хувийн
хэвшлийн
эрүүл мэндийн
байгууллага

**НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН
ЗОРИЛТОТ ТҮВШИН**



Д/д	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт 2022	Хүрэх түвшин			
			2023	2024	2025	2026
1	Хүн амын дундаж наслалт	74.6	75	75	76	76
1	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	84.3	84	84	85	85
2	Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	70.6	70	71	71	72
3	Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	64.8	60	62	62	65
4	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	72.7	70	72	72	75
5	Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	20	36	41	46	50
6	Өрхийн, сумын эрүүл мэндийн төвийн нийт үзлэгт гэрийн эргэлтийн эзлэх хувь	16.4	17	18	19	20
7	Товлолт дархлаажуулалтын хамралтын хувь (товлолын ангиллаар)	95.5	96	96	97	97
8	Жирэмсний эхний 3 сард хяналтанд орсон эхийн эзлэх хувь	89.1	90	91	92	95
9	Эхийн эндэгдлийн түвшин (100000 амьд төрөлт тутамд)	72.2	50	30	20	15
10	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	14.4	15	12	9	8
11	Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	8.2				
12	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	20.9	20	18	15	12
13	Амьгүй төрөлтийн түвшин, 1000 төрөлтөд	6.8	6.5	6	5.5	5
14	Сүрьеэгийн нас баралтын түвшин (10000 хүн амд)	0	0	0	0	0
15	Вируст гепатитын өвчлөлийн түвшин (10000 хүн амд)	1.1	1	0.5	0.5	0
16	Даралт ихсэх өвчний шалтгаант нас баралтын түвшин (0-74 насны 10000 хүн амд)	0.3	0.3	0.2	0.2	0.1
17	Зүрх судасны өвчлөлөөс шалтгалсан нас баралтын түвшин (10000 хүн амд)	21.8	20	18	16	14
18	Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин (10000 хүн амд)	8.2	8	7.5	7	7



Стратеги боловсруулсан:

Ш.Иманхан – Эрүүл мэндийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга

А.Ерганат – Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга

---oOo---

ЕС. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /Хэрэгжүүлэх арга хэмжээ/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2022 он	Зорилтот түвшин			Санхүүгийн эх үүсвэр
				2023 он	2024 он	2025 он	
Ерөнхий чиг үүргийн нэр: ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ, ХАМГААЛАХ							
Үндсэн чиг үүрэг 1. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ							
Зорилт-1. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар Иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг оношилгоо шинжилгээнд жил бүр хамруулна.	Арга хэмжээ-1. Аймагт хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулна.	Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулагдана.	0	0	1	1	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр, Эрүүл мэндийн даатгалын сан
	Арга хэмжээ-2. Эрүүл мэндийн байгууллагуудын веб хуудас, цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр орон нутгийн иргэдийн онцлог тохирсон хэлбэрээр эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.	Бэлтгэн түгээсэн сэдэвчилсэн мэдээллийн тоо	40	65	70	90	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
	Арга хэмжээ-3. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамруулах үйл ажиллагаа зохион байгуулна.	Эрүүл мэндийн дэмжих төвд үзлэгт хамрагдсан иргэдийн тоо, хувь	20	36	41	50	Эрүүл мэндийн даатгалын сан
	Арга хэмжээ-4. Эрүүл идэвхтэй	Төлөвлөгөө тус	60	65	70	75	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр

10

	амьдрал, Хавдрын эсрэг, Харшлаас сэргийлэх, Эрүүл чийрэг эр хүн, Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд, Орчны эрүүл мэнд, Элэг бүтэн Монгол арга хэмжээний төлөвлөгөөнүүдийн орон нутаг дахь хэрэгжилтийг хангаж ажиллана.	бүрийн хэрэгжилтийн дундаж хувь					орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр, Эрүүл мэндийн даатгалын сан
	Арга хэмжээ-5. Товлолт дархлаажуулалтын хамрагалтыг нэмэгдүүлнэ.	Товлолт дархлаажуулалтын хамрагалтыг хувь	95.5	96	97	97	Улсын төсөв
Зорилт-2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, байгалийн гамшиг, шинэ болон сэргэн тархах байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандан судлах, хариу арга хэмжээ шуурхай авах чадавхийг бүрдүүлнэ.	Арга хэмжээ-6. Гэнэтийн аюул, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээ авах эрүүл мэндийн салбарын ажилтан, эмч мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулах дадлага сургалтыг зохион байгуулна.	Сургалтанд хамрагдсан хүний тоо	100	150	200	250	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
	Арга хэмжээ-7. Шинэ болон сэргэн тархах байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, нөөц бүрдүүлнэ.	Нөөцийн бэлэн байдлын судалгаа	1 сарын нөөцтэй	1 сарын нөөцтэй	2 сарын нөөцтэй	2 сарын нөөцтэй	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
	Арга хэмжээ-8. Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	70	75	80	85	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл

0019

М.С. Дорж

Улсын төсөв, олон улсын төсөл

	Арга хэмжээ-9. Бэлгийн замаар дамжих халдварыг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	Идэвхтэй илрүүлэг үзлэгт хамрагдалтын тоо, эмчилгээнд хамрагдсан хувь	-	1065, 80%	2000, 80%	5000, 90%	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
	Арга хэмжээ-10. Сүрьеэ өвчний тархалтыг бууруулах, сүрьеэгээс сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулна.	Илрүүлэг үзлэг, сургалт мэдээлэлд хамрагдсан хүний тоо	2100	550	700	1000	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
Зорилт-3. Халдварт өвчнөөс сэргийлэх хянах, илрүүлэх тогтолцоог бэхжүүлнэ.	Арга хэмжээ-11. Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх чиглэлийн судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг дэмжинэ.	Хийгдсэн судалгаа, эрдэм шинжилгээний ажлын тоо	1	1	2	3	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
	Арга хэмжээ-12. Агаар, хөрсний бохирдлоос үүдэлтэй өвчлөлийг бууруулах, угаарын хийн хордлогоос сэргийлж ажиллана.	Угаарын хийн хордлогын тохиолдол	-	64	Өмнөх тохиолдлоос бууруулна	Өмнөх тохиолдлоос бууруулна	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
	Арга хэмжээ-13. Зохистой хооллолтыг төлөвшүүлэх, бага насны хүүхдийг хоол тэжээлийн дутагдлаас сэргийлэх ажил зохион байгуулна.	Хоол, тэжээлийн дутагдалтай хүүхдийн тоо		Өмнөх тохиолдлоос бууруулна	Өмнөх тохиолдлоос бууруулна	Өмнөх тохиолдлоос бууруулна	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
Үндсэн чиг үүрэг 2. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ							


500019

12

Зорилт-4. Оношилгоо эмчилгээний орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт технологийг нэвтрүүлэн иргэд орон нутагаа эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлж, лавлагаа шатлал руу илгээх иргэдийн урсгалыг 20 хувь бууруулна.	Арга хэмжээ-14. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хүн амын нягтрал, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх анхан шатны эрүүл мэндийн байгууллага, нэгжийн тоог нэмэгдүүлнэ.	Эрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөл	4	4	4	6	Улсын төсөв
	Арга хэмжээ-15. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах, дэвшилтэт технологийг нутагшуулахад дэмжиж ажиллана. (урологи түрүү булчирхайн хагалгаа, эмэгтэйчүүдийн дурангийн мэс засал, 48, 72, 96 цагийн холтер, бүлэн хайлуулах эмчилгээ, хүүхдийн түлэнхийн эмчилгээ)	Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо	-	Тохиолдлын тоогоор	Тохиолдлын тоогоор	Тохиолдлын тоогоор	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
	Арга хэмжээ-16. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт зүрхний шигдээс, тархины цус харвалтын оношлогоо, эмчилгээний нэгж байгуулна.	Нэгж байгуулж, тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо	-	Тохиолдлын тоогоор	Тохиолдлын тоогоор	Тохиолдлын тоогоор	Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ-17. Хавдрын хими эмчилгээг орон нутагаа үзүүлнэ.	Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо	-	Тохиолдлын тоогоор	Тохиолдлын тоогоор	Тохиолдлын тоогоор	Улсын төсөв, Орон нутгийн төсөв
Арга хэмжээ-18. Өрх, сум,		Тусламж					Улсын төсөв

0019

13



	тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх эмнэлгийн анхан шатлалын тусламж үйлчилгээнд шинэ дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэх, лабораторийн оношилгоо, өдрийн, сэргээн засах, гэрээр үзүүлэх тусламжийг бэхжүүлнэ.	үйлчилгээ авсан иргэдийн хувь						Орон нутгийн төсөв
	Арга хэмжээ-19. Амбулаторын тусламж үйлчилгээний үйл ажиллагааг нэмэгдүүлж, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийн кабинетүүд нээнэ.	Нэмэгдүүлсэн кабинетийн тоо	-	2	4	5		Улсын төсөв
	Арга хэмжээ-20. Өдрийн эмчилгээний тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Өдрийн эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	200					Улсын төсөв
	Арга хэмжээ-21. Аймгийн Нэгдсэн эмнэлгийг MRI аппарат, маммографийн аппарат, суурин болон зөөврийн рентген, ангиографи, ясны сийрэгжилтийн аппарат, угаарын хийг хэмжих карбоксиметр, дурангийн хагалгааны аппарат, спирогрaммийн аппарат, TNR аппарат, шүдний дэлгэмэл зураг авах аппаратаар хангана.	Хангагдсан тоног төхөөрөмжийн тоо	-	1	3	5		Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр, Эрүүл мэндийн даатгалын сан
Зорилт-5. Яаралтай	Арга хэмжээ-22. Эмнэлгийн яаралтай болон түргэн	Парк шинэчлэл хийгдсэн тоо	5	1	5	5		Улсын төсөв, орон нутгийн




тусламжийн чанар, хүртээмж, чадавхийг сайжруулна.	тусламжийн парк шинэчлэлийг хийнэ.								тусөв, олон улсын төсөл хөтөлбөр, Эрүүл мэндийн даатгалын сан
	Арга хэмжээ-23. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн өрөөг стандартын дагуу зохион байгуулан шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, хүний нөөцийг чадвхжуулна.	Чававхжуулах сургалтанд хамрагдсан ажилтны тоо	2	1	18	36			Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр, Эрүүл мэндийн даатгалын сан
	Арга хэмжээ-24. Осол гэмтэл их бүртгэгддэг зарим сумдад яаралтай тусламжийн цэг байгуулна.	0	0	1	2	2			Орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр, Эрүүл мэндийн даатгалын сан
	Арга хэмжээ-25. Эрүүл мэндийн ажилтнуудыг эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн чиглэлээр бэлтгэнэ.	Яаралтай болон түргэн тусламжийн чиглэлээр бэлтгэгдсэн ажилтны тоо	2	1	18	36			Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр, Эрүүл мэндийн даатгалын сан
Зорилт-6. Эрх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалж, эндэгдлийг бууруулна.	Арга хэмжээ-26. "Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих сан"-гийн журмыг боловсронгуй болгож, сангийн болон "Эх, нярайн цомог"-ийн хөрөнгийг нэмэгдүүлэн хүртээмжийг	Эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад орон нутгаас хуваарилсан төсөв	19 сая	20 сая	25 сая	30 сая			Орон нутгийн төсөв




сайжруулна.		Жирэмсэний эрт үеийн хяналтын хувь, хүүхдийн хяналт, гэрийн эргэлтийн эзлэх хувь	89.1, 16.4	90, 17	92, 18	92, 19	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
Арга хэмжээ-27. Эх, хүүхдийн хяналтыг бүх шатанд сайжруулан хяналтын системийг бий болгож, үр дүнг тооцно.							
Арга хэмжээ-28. Аймгийн хэмжээний нийт нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн суурь өвчинг илрүүлэх судалгаа хийж, гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр сургалт зохион байгуулах ажлыг бүх сум, багийн түвшинд хэрэгжүүлнэ.		Эрүүлжүүлж, сургалтанд хамрагдсан нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тоо	-	2000	2500	3000	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
Арга хэмжээ-29. Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийг амаржих газрын статустай болгох асуудлыг шат дараалан шийдвэрлүүлнэ.		Амаржих газар байгуулагдана	0	0	1	1	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр, Эрүүл мэндийн даатгалын сан
Үндсэн чиг үүрэг 3. ЭМ ЗҮЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ							
Зорилт-7. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэн	Арга хэмжээ-31. Эм зүйн салбарт мөрддөг стандартад үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангуулан ажиллана.		50	60 эмийн санд	60 эмийн санд	60 эмийн санд	Улсын төсөв
	Үнэлгээнд хамрагдсан байгууллагын тоо, өгсөн зөвлөмж						
	Арга хэмжээ-32. Антибиотик		200	300	350	400	Улсын төсөв,

Зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмжийг 90 хувьд хүргэнэ.	тэсвэртэй нянгийн тэсвэржилтийн тандаж, эмэнд нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.	Арга хэмжээ-33. Эмч мэргэжилтэн, иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх сургалт мэдээллийг зохион байгуулна.	Сургалтад хамрагдсан хүний тоо	эмнэл гийн ажилтан	1000	1200	1400	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
	Арга хэмжээ-34. Эрүүл мэндийн газрын дэргэд эм, эмнэлгийн хэрэгслийн агуулах барина.	Эмийн нөөц бүрдэлт	-	1-2 сарын нөөцтэй	1-2 сарын нөөцтэй	Олон улсын төсөл хөтөлбөр		
	Арга хэмжээ-35. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар, тохируулга, баталгаажилтыг жил бүр хийнэ.	Засвар, баталгаажилт, тохируулга хийгдсэн тоног төхөөрөмжийн тоо	-	343	350	Улсын төсөв		
	Үндсэн чиг үүрэг 4. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ							
Зорилт-8. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг чадавхжуулж, нийгмийн хамгааллыг сайжруулж, шаардлагатай мэргэжилтэнг жил бүр бэлтгэнэ.	Арга хэмжээ-37. Салбарын хүний нөөцийн сургалт хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгцээний дагуу хүний нөөцийг бэлтгэнэ.	Салбарын хүний нөөцийг төлөвлөлтийн биелэлтийн хувь	75%	80%	85%	90%	Орон нутгийн төсөв	
	Арга хэмжээ-38. Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор тасралтгүй сургалтад хамруулна.	Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо	17 чиглэлээр 72 эмнэл гийн ажилтан	68	75	85	Улсын төсөв, Орон нутгийн төсөв	
	Арга хэмжээ-39. Эрүүл мэндийн	Гадаад	Гадаад	Гадаад	Гадаад	Гадаад	Улсын төсөв,	




салбарын ажилтан, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэжлийн чиглэлээр өндөр хөгжилтэй улс орнуудад богино болон урт хугацаагаар сургаж, мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	сургалтад хамрагдсан ажилтан, албан хаагчдын тоо	сургалт 7, дотоод сургалт 75%	сургалт 13, дотоод сургалт 85%	сургалт 20, дотоод сургалт 90%	сургалт 25, дотоод сургалт 95%	орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
Арга хэмжээ-40. Лавлагаа шатлалын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг аймагт урьж ажиллуулж, тэдэнд орон нутгаас болон тухайн эмнэлгээс дэмжлэг үзүүлнэ.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	2	5	6	8	Улсын төсөв, Орон нутгийн төсөв
Арга хэмжээ-41. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг нарийн мэргэжлийн эмчээр хангана.	Хангалтын хувь	80%	83%	85%	90%	Улсын төсөв, Орон нутгийн төсөв
Арга хэмжээ-42. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийг аймгийн нэгдсэн эмнэлэгт, аймгийн нэгдсэн эмнэлгийн эмч, мэргэжилтнийг лавлагаа шатны эмнэлэгт чадавхжуулна.	Сургалтанд хамрагдсан эмч, мэргэжилтний тоо	9	21	30	45	Улсын төсөв, Орон нутгийн төсөв
Арга хэмжээ-43. Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, тогтвор сууршилтай ажиллах орчин, нөхцлийг бүрдүүлнэ.	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	75%	85%	90%	95%	Улсын төсөв, орон нутгийн төсөв
Арга хэмжээ-44. Эрүүл мэндийн удирдах менежерүүдийн ур чадварыг	Сургалтанд хамрагдсан удирдах	2	1	5	10	Улсын төсөв, орон нутгийн төсөв



нэмэгдүүлэх, чадавхжуулах сургалтанд хамруулна.		ажилтны тоо						
Арга хэмжээ-45. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжлийн нийгэмлэг, холбоодын хамтын ажиллагааг сайжруулна.		Зохион байгуулсан арга хэмжээний тоо	6	5	10	13	Улсын төсөв, орон нутгийн төсөв	
Үндсэн чиг үүрэг 5. ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТ								
Зорилт-9. Эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг худалдан авч байхаар эрүүл мэндийн даатгалын үр дүн, үр ашиг бүхий санхүүжилтэд шилжүүлж бүх нийтийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулна.	Арга хэмжээ-46. Аймгийн Нэгдсэн эмнэлгийг гүйцэтгэлийн санхүүжилт болон удирдлагын бие даасан хэлбэрт үе шаттай шилжүүлж, ажилтны гүйцэтгэлд суурилсан цалин, урамшууллын тогтолцоог төлөвшүүлнэ.	Гүйцэтгэлийн санхүүжилт	Гүйцэтгэл зэр	Гүйцэтгэл лээр	Гүйцэтгэл лээр	Гүйцэтгэл лээр	Эрүүл мэндийн даатгалын сан	
	Арга хэмжээ-47. Төсөв санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангана.	Шилэн дансны мэдээллийн хувь	92	97	99.5	100	-	
	Арга хэмжээ-48. Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа болон төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд "Аудитын олон улсын стандарт", Сангийн сайдын 2019 оны 268 дугаар тушаалаар батлагдсан "Улсын салбарын дотоод аудитын аргачлал"-ын дагуу эрсдлийн үнэлгээ хийж,	Хийгдсэн эрсдлийн үнэлгээ, өгсөн зөвлөмжийн тоо	1	1	1	1	Улсын төсөв, орон нутгийн төсөв	



	түүний дагуу дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөмж гаргах, хэрэгжилтэд хяналт тавина.						
Үндсэн чиг үүрэг 6. ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ							
Зорилт-10. Телемедицин, цахим эрүүл мэндийн дэвшилтэт технологийг өргөжүүлнэ.	Арга хэмжээ-49. Алсын зайн оношилгоо, зөвлөгөө, мэдээлэл солилцох (телемедицин) тусламж, үйлчилгээг нэмэгдүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх шатлалд хэрэгжүүлэн ажиллана.	Тусламж, үйлчилгээ авсан иргэдийн тоо	14	Тохиолдлын тоогоор	Тохиолдлын тоогоор	Тохиолдлын тоогоор	Улсын төсөв, орон нутгийн төсөв
	Арга хэмжээ-50. Өрх, сумын эрүүл мэндийн төвд үзүүлэх эмнэлгийн анхан шатлалын тусламж, үйлчилгээнд Мобайл технологийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	Хамрагдсан хүний тоо	8744	9000	9500	10000	Улсын төсөв, орон нутгийн төсөв, олон улсын төсөл хөтөлбөр
Үндсэн чиг үүрэг 7. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ							
Зорилт-11. Эрүүл мэндийн салбарын удирдлага зохион байгуулалт, ил тод	Арга хэмжээ-51. Эмнэлгийн үйлчилгээг сайжруулж, шинэ түвшинд хүргэх менежментийн шилдэг туршлагыг судлан, нэвтрүүлнэ.	Нэвтрүүлсэн шинэ туршлагын тоо	2	2	2	2	Улсын төсөв, орон нутгийн төсөв



байдлыг хангаж ажиллана.	Арга хэмжээ-52. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээ, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөнтэй уялдуулан эрүүл мэндийн салбарын тэргүүлэх чиглэлийн дагуу олгоно.	Шинээр зөвшөөрөл авсан байгууллагын тоо	16	7	Шаардлага хангасан төслийн тоогоор	Шаардлага хангасан төслийн тоогоор	Улсын төсөв, орон нутгийн төсөв
	Арга хэмжээ-53. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ил тод байдлыг хангаж ажиллана.	Ил тод байдлын хэрэгжилтийн хувь	80%	85%	90%	95%	Улсын төсөв, орон нутгийн төсөв
	Арга хэмжээ-54. ЭМГ-ын бүтэцэд хяналт шалгалтын бүтцийг шинээр байгуулж, эрүүл мэндийн салбарын хяналт шалгалтын гүйцэтгэл, үр дүнг тооцно.	Хийгдсэн хяналт шалгалтын тоо					Улсын төсөв, орон нутгийн төсөв